



УЛААНБААТАР ХОТЫН  
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН  
ТУШААЛ

2020 оны 01 сарын 10 өдөр

Дугаар 406

Улаанбаатар хот

С.Аригуун, М.Гансэлэм нарыг  
сургалтад хамруулах тухай

Төрийн албаны тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.7, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус албаны Хотын тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Мажигсүрэнгийн Гансэлэм, Хог хаягдлын удирдлага зохицуулалтын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Саранхүүгийн Аригуун нарыг БНСУ болон Монгол Улсын иргэд хоорондын харилцаанд шинэ эхлэлийг тавихаар зорьж буй БНСУ дахь Монголын Соёл Эдийн Засгийн төвийн үйл ажиллагаатай танилцах уулзалт, сургалтад 2020 оны 01 дүгээр сарын 16-наас 2020 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийг дуустал хугацаанд оролцуулсугай.

2. С.Аригуун, М.Гансэлэм нарт дотоод журмын 6 дугаар зүйлийн 6.33 дахь заалтын дагуу сургалтад хамрагдсан хугацааны цалинг олгохыг Ахлах нягтлан бодогч /Б.Цэрмаа/-д зөвшөөрсүгэй.

3. С.Аригуун, М.Гансэлэм нарын сургалтад хамрагдах хугацаанд ажил үүргийг нь орлон ажиллах хуваарийн дагуу холбогдох мэргэжилтэнд хариуцуулан өгч, хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлага, санхүүгийн хэлтсийн дарга Э.Энхцэцэгт үүрэг болгосугай.

4. Сургалтын тайланг ирснээс хойш ажлын 5 хоногийн дотор Захиргааны удирдлага, санхүүгийн хэлтэст ирүүлэхийг М.Гансэлэм, С.Аригуун нарт даалгасугай.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР  
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ  
ДАРГА  Т.ГАНТӨМӨР

